

## АНТИГЛОБАЛИЗМ

*Д.Бямбажав\**

### Өмнөх үг

1999 онд Америкийн Сиетл хотноо болсон Дэлхийн худалдааны байгууллагын хуралдааны үеэр олон мянган хүн глобальчлалыг эсэргүүцэн жагсаж, ДХБ-руу дайран орох гэсэн оролдлого гарч цагдаа нар болон жагсагчидийн хооронд тэмцэл өрнөн, эцэст нь нулимс асгаруулагч хэрэглэн намжааж байжээ. Түүнээс хойш ийм үйл явдал Вашингтон, Женев, Давос зэрэг олон хотод давтагдсан. Эдгээр хүмүүс глобальчлалыг яагаад эсэргүүцэх болов? Глобальчлалыг эсэргүүцэгчидийн үндэслэл юу болох? Эсэргүүцэл нь ямар цар хүрээтэй байна вэ? Эдгээр асуултад хариулт олохыг зорилоо.

### Глобальчлал гэж юу вэ?

Антиглобализмын тухай ярихын тулд бид юуны өмнө глобальчлал гэж юу болох, түүнийг хэрхэн ойлгож буйгаа тодорхойлъё.

Сүүлийн 20-иод жилд ялангуяа 1990-ээд оноос хойш дэлхий дахинаа глобальчлалын тухай асуудлаар марган мэтгэлцэх, судлан шинжлэх, ном бүтээл туурвих явдал өргөн далайцтай болжээ. Ерөөс глобальчлал хэмээх ойлголт улс болгоны хэлэнд нэвтэрч өдөр тутмын хэллэг болон хувирчээ.

Тэдгээр маргаан мэтгэлцээн, судалгаа шинжилгээ нь глобальчлалыг олон тал, өнцгөөс авч үзэж, талархан дэмжих, шүүмжлэн буруушаах, дасан зохицох зэрэг олон хандлагын илэрхийлэл юм. Бидэнд глобальчлалын тухай нэгдмэл нэг тодорхойлолт, тайлбар байхгүй ч нийтлэг гэгдэхүйц ойлголт хандлага байна. Олон янзын тодорхойлолт тайлбар бий ч миний бие дараах хоёр тодорхойлолтыг илүү онцлон үзэв. Үүнд:

- q Глобальчлал гэдэг бол улс үндэстэн, зах зээл болон технологийн эргэлт буцалтгүй интеграцчилал юм.<sup>1</sup> Энэ хэдийгээр олон хэмжээст үйл явц ч гэсэн түүний суурь нь эдийн засгийн интеграци, либералчлал болж байна.
- q Глобальчлал гэдэг бол дэлхий дахин улам бүр нэгдмэл болж, норм стандарт, журам үйл ажиллагаа хаа ч газар ижилсэх үйл явц юм.<sup>2</sup>

Дээрх хоёр тодорхойлолтын хүрээгээр бид антиглобализмын тухай авч үзэх нь оновчтой гэж үзлээ.

\*Д.Бямбажав - УБИС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш

### Антиглобализм гэж юу вэ?

Өнөөдөр глобальчлалыг шүүмжлэн буруушааж, эсэргүүцэж буй үзэл санаа, парадигм, олон нийтийн хөдөлгөөнийг нийтэд нь энэ ойлголтоор тэмдэглэж байна. Аливаа зүйлд эерэгийн зэрэгцээ сөрөг тал байдгийн адил глобальчлалд ч гэсэн ноцтой сөрөг талууд бий. Эдгээр нь түүнийг шүүмжлэх эсэргүүцэх шалтгаан болж байна. Хүрээлэн буй орчныг хамгаалагчид, үйлдвэрчний эвлэлийнхэн, хөдөө аж ахуй эрхлэгчид, эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, шашны фундаменталистууд глобальчлалыг эсэргүүцэгчидийн цөмийг бүрдүүлж байна. Тэдний үйл ажиллагаа олон хэлбэрээр илэрч байна. Энгийн олон нийтийн хөдөлгөөнөөс эхлээд хүчирхийллийн аргыг хүртэл зарим бүлэг сонгож байна.

1997 оны намар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хөрөнгө оруулалтын талаарх олон талт тохиролцоонд хүрсэнийг эсэргүүцсэн эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөсөн нь антиглобализм зохион байгуулалттай гарч ирсэн түүхэн тохиолдол байв. Эдгээр жагсагчид Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын ордонд нэвтрэн орж өөрсдийн нууцаар (интернетээр) тохиролцож боловсруулсан хөрөнгө оруулалтын тухай төслөө танилцуулж байсан юм. Тухайн үед энэ хөдөлгөөнд 40 мянга орчим идэвхтнүүд ажиллаж байсан байна. Цаашид ийм жагсаал хөдөлгөөн ДХБ, Олон улсын валютын сангийн хурал чуулган бүртэй давхцан гарах болсон. Хамгийн сүүлчийн жишээ нь энэ оны 3 сард Давост болсон Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын үер антиглобалистууд мөн л жагсан эсэргүүцэж байсан.

Глобальчлалын үйл явц нь хүмүүст эмзэгээр тусч, хохирол учруулж буй нь ийм эсэргүүцэгч хүчнийг бий болгож байна. Өрнө болоод Дорнодод аль алинд нь ийм хүчин өнөөдөр байна. Өнөөдөр олон улсад глобальчлалыг шүүмжлэн үзсэн олон арван ном бүтээл гарч байна. Ийм хандлагаар бичигдсэн ном бүтээл Францад нилээд их ажиглагддаг бөгөөд бүр төрийн бодлогын хэмжээнд хүрсэн гэж хэлж болох юм.<sup>3</sup> Америк, Баруун Европд, Б.Барбер, Д.Кортен, Г.Дейми, Дж.Голдсмит, И.Рамоне, С.Моизи нар глобальчлалыг шүүмжлэн үзэгч нэр бүхий судлаачид болж байна. Хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнуудад ч шүүмжлэлт хандлагаар бичигдсэн ном бүтээл байхын сацуу тэдгээр орны улс төрчдийн төвшинд ч ийм хандлага бас байдаг.

## **Глобальчлалыг эсэргүүцэгчидийн үндэслэл юу вэ?**

Глобальчлалыг эсэргүүцэх болсон олон шалтгаан бий. Энд миний бие үндсэн гэж гэж хэлж болох есөн үндэслэлийг товч авч үзье.

1. Р.Франк, Ф.Кук нар дэлхий дахинд тэгш бус байдал газар авахад глобальчлал чамгүй үүрэг гүйцэтгэжээ<sup>4</sup> хэмээн дүгнэжээ. Үүний нотолгоо болох олон тоо баримтыг бид олж үзэж болно. Зарим нэгийг нь дурдья.

НҮБ-аас гаргасан тоо баримтаар дэлхийн нийт бүтээгдэхүүн сүүлийн 50 жилд 3 триллионоос 30 триллион болтлоо өсөн нэмэгджээ. Гэвч бүтээсэн баялгийн хуваарилалт тэгш бус байсан нь нийгмийн тэгш бус байдал газар авахад хүргэжээ. Хөгжингүй орны нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 25-30 мянган доллар бол дэлхийн нийт хүн амын 85 хувийнх нь нэг хүнд оногдох ДНБ 3 мянган доллараас бага байна. Дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүн, дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалт зэрэгт эзлэх хувь хэмжээ нь баялгийн хуваарилалтыг харуулахын сацуу хүний хөгжлийн индекс ямар их зөрөөтэй буйг бид олж харах болно. Глобальчлалаас өмнө 1960 онд дэлхийн хүн амын баян гэгдэх 20 хувь нь ядуу 20 хувиасаа 30 дахин баян байв. Глобальчлалын оргил үе буюу 1997 онд хамгийн хөрөнгөлөг 20 хувь нь ядугаасаа 74 дахин баян болжээ.<sup>5</sup> 1:30 байсан бол 1:74 болон зөрөө нь улам нэмэгджээ. Энэ ялгаа өдөр ирэх тусам нэмэгдэж буй глобальчлалд сөргөөр хандах өргөн хандлагыг бий болгож байна.

2. Хөгжингүй орнуудад глобальчлалыг зүүний болон барууны хүчний зүгээс эсэргүүцэж байна. Зүүний зүгээс орлогын тэгш бус хуваарилалт, нийгмийн ялгарлыг шүүмжилж байна. Ялангуяа социал-демократууд илүүтэй шүүмжилдэг. Францын ерөнхий сайд Л.Жоспен неолиберализмын харгис хэрцгий байдал нь хүн төрөлхтний иргэншлийн хүмүүнлэг шинжийг үгүйсгэж байна гэсэн нь зүүний гол байр суурь юм. Глобальчлалыг социаль талаас нь шүүмжлэхээс гадна үндэсний үзэл, соёл уламжлалаа дээдлэх үүднээс түүнийг эсэргүүцэх явдал Өрнөдөд мөн байна. Германы Ардын нам, Австрийн Ардын Эрх Чөлөөний нам, Австралийн Нэгдмэл Үндэстний нам зэрэг нь үүнд хамаарна.

3. Женерал Моторс компани Мексик дахь ажилчиддаа цагт 1,54 доллар төлдөг бол АНУ дахь ажилчиддаа цагт 18,96 доллар өгдөг. Энэ нь америкийн болоод Өрнөдийн ажилчидын өрсөлдөх чадварт муугаар нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, тус компани АНУ дахь үйлдвэрээ Мексикт шилжүүлсэн нь илүү ашигтай болох нь

ойлгомжтой юм. Үүний үр дүнд Өрнөдөд ажилгүйдэл ихсэх, ажилчидын цалин буурах явдал нэмэгдсэн байна. Энэ нь үйлдвэрчний эвлэлийнхний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарах шалтгаан болжээ. Нөгөөтэйгүүр, буурай хөгжилтэй улс орнуудын ажилчидын аюулгүй байдал, цалин хөлс, эрх нь ноцтой зөрчигдөж буйд тэд эгдүүцэж байна.

4. Хүрээлэн буй орчны асуудалтай холбоотойгоор глобальчлалыг шүүмжлэгчид дэлхий нийтийн компаниуд бус нутгийн экологид хохирол учруулах, дэлхий нийтэд хохирол учруулах, байгаль орчныг бусниулах зэргээр эдийн засгийн ашиг хонжоо хайж буйг олон талаар баталдаг. Мөн чөлөөт худалдаа, шилжих хөдөлгөөн, аялал жуулчлал нь дэлхий даяар өвчин тархалтыг ихэсгэж байгаа нь хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн нэгэн жишээ юм.

5. Дэлхий дахинд санхүүгийн капиталын олон төрөл нь үндэстэн болон дэлхий дахины аюулгүй байдалд асар их хохирол учруулж байна.<sup>6</sup> Хөрөнгийн зах зээл өөрийн мөн чанараар маш тогтворгүй бөгөөд улс үндэстэн бүр мөнгөн тэмдэгтээ хамгаалах, үндэсний эдийн засаг, нийгмээ уналтаас сэргийлэх томоохон асуудалтай тулгарч байна. Хөрөнгийн чөлөөт зах зээл бус харин бараа бүтээгдхүүний л чөлөөт зах зээл рүү тэмүүлэх ёстой болж байна.

6. Глобальчлал бол Өрнөжилт, Өрнөжилт бол Америкчлал гэдэг үзэл. Өрнийн, Америкийн соёл, үнэлэмж, стандарт дэлхий дахинаа түгэн дэлгэрч буй нь өрнийн бус иргэншилт улс орнуудад түүнийг эсэргүүцэх, эсрэг түрэлтийг бий болгох гэсэн оролдлогыг улам дэлгэрүүлж байна. Үндэсний үзэлтнүүд, шашны фундаменталистуудын эсэргүүцлийн нэгэн шалтгаан нь энэ болж байна.

Өнөөдөр Интернет дэлхий дахины харилцаа холбооны нэг үндсэн хэрэгсэл болж түүний албан ёсны хэл нь англи хэл болж байна. Гэтэл дэлхийн хүн амын 10-ний ес нь англи хэлийг мэдэхгүй байх юм. Хүн төрөлхтний түүхийн туршид ойролцоогоор 10 мянга орчим ярианы хэл байжээ.<sup>7</sup> Одоогоор 6 мянга орчим хэлийг ямар нэгэн төвшинд хэрэглэж буй ч дийлэнх хэлийг шинэ залуу үеийнхэнд заадаггүй бөгөөд үхмэл болон хувирч байна. Үндсэндээ 300 орчим хэл л хэрэглээнд байна. Хэл устана гэдэг бол соёл устахын эхлэл гэж үзэж болох юм. Үндэсний хэл соёл, үнэлэмж, уламжлал глобальчлалын давалгаанд уусан алга болох, түүнд нийцээгүй нь шоовдорлогдох хандлага ажиглагдах болжээ.

7. Төр улсын бүрэн эрхт байдал (суверенитет) Олон улсын харилцаанд төр улс үндсэн оролцогч нь болж давамгайлж ирсэн

тогтолцоо хувьсан өөрчлөгдөж, өнөөдөр төрийн бүрэн эрхт байдал нь олон улсын байгууллага, дэлхийн зах зээл, бусад улсын нөлөөгөөр хумигдан, тухайн улс өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд дээд эрх мэдлийг бие паан хэрэгжүүлэх бүрэн эрх нь олон талаар хумигдаж буй их гүрний болоод жижиг улсын аль алины жишээн дээр харж байна.

8. Чанар муу, хямд үнэтэй бүтээгдэхүүн тухайн улсын зах зээлд ихээр орж ирэх, тэдгээр улсуудын үндэсний үйлдвэрлэлийг хямралд оруулах, хэрэглэгчидийн эрх ашгийг зөрчих явдал нийтлэг байгаа нь глобальчлал, нээлттэй чөлөөт худалдааг эсэргүүцэх хөдөлгөөнийг бий болгож байна. Энэ нь ялангуяа өрнөдийн хөдөө аж ахуй эрхлэгчидийн хүрээнд ноцтой асуудал үүсгэж, тэдний зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгардаг.

9. Глобальчлалд ардчиллын дутал байна. Глобальчлал ба ардчиллын үйл мөр зэрэгцэн явж ирсэн нь ардчиллын гурав дахь давалгаанаас хойш, ялангуяа 1980-1990 оны хугацаанд Ази, Африк, Латин Америкийн олон оронд ардчилсан дэглэм тогтож байснаар харагдана. Фридом Хаусын судалгаагаар 1998 онд дэлхийн 191 орны 117 нь олон намын тогтолцоо, өрсөлдөөнт сонгууль бүхий улс орнууд байсан байна. Ийм байхад яагаад ардчиллын дутал байна гэж?

Ардчиллын дутал 3 төвшинд тод илэрч байна.

1. Ардчилал бол ард түмний засаг хэмээх зарчимд өөрчлөлт оруулж, тухайн ард түмэн нутаг дэвсгэрийнхээ хүрээнд өөрсдийгөө засаглах нь хязгаарлагдмал болж байна.<sup>8</sup>
2. Үндэстэн дамнасан болон олон улсын байгууллагын (дэлхийн, бүс нутгийн) бодлого, шийдвэр, үйл ажиллагаа нь ардчилсан бус зарчмаар хэрэгжиж байна.
3. Нийгмийн тэгш бус байдал, зүй бус байдлаас хамаараад дэлхийн зах зээл, холбоо харилцаа, иргэний нийгмийн харилцаанд дэлхийн нийт иргэд тэгш эрхтэйгээр, бүх нийтээр оролцох боломж бүрэн хэрэгжихгүй байна.

### Дүгнэлт

Глобальчлал бол сонголт биш, энэ бол бодит байдал, глобальчлалд хамрагдах эсэхийн тухай асуудал байх боломжгүй хэмээх ойлголт өнөөдөр түгээмэл болжээ. Гэвч хүний аюулгүй байдал, нийгмийн зүй ёс, ардчиллыг ноцтой хохироох байдал нь багасахгүй тохиолдолд энэ үйл явц зохистой үр дүнд хүрэх эсэх нь эргэлзээтэй юм. Хэдийгээр антиглобализм гэсэн нэрийн дор авч үзсэн дээрх

нийгмийн бүлгүүд, үзэл санаа нь нэгдмэл нэгэн хүчин болоогүй байгаа ч учруулж буй занал, хохирол нь олдож буй ашиг, боломжоос нь хэтэрвэл нэгдмэл биш ч нэг тийш хандсан улам хүчтэй түрлэгийг бий болгож ч болох юм.

Дээр авч үзсэн үндэслэлүүд нь бидэнд ч мөн хамаарах нь ойлгомжтой. Монгол улсын өнөөгийн нийгэм, эдийн засагт тулгамдаж буй асуудлуудыг глобальчлал улам сэдрээж болох ч бас олгож буй олон давуу талууд бий гэдгийг манай судлаачид онцлон бичсэн бий. Глобальчлалыг эсэргүүцэгчидийн шалтгаан үндэслэлийг бид ойр болон хэтийн зорилт, бодлогодоо харгалзан тусгах нь нэн чухал гэж дүгнэе.

### Эшлэл

- <sup>1</sup> Friedman T.L. (2000) *The Lexus and Olive Tree*. New York: HarperCollins. P. 9
- <sup>2</sup> В.Хэндэрсоны гаргасан дүгнэлт.
- <sup>3</sup> А.И.Уткин (2001) *Глобализация: процесс и осмысление*. Москва:Логос. Стр 102
- <sup>4</sup> Мөн тэнд. 140-р тал
- <sup>5</sup> *Dueling Globalizations: A debate between Thomas L.Friedman and Ignacio Ramonet*. Foreign Policy, Fall 1999. pp.110-129
- <sup>6</sup> Глобальчлал, Монгол улсын хөгжил. УБ.,2002. 21 дэх тал
- <sup>7</sup> А.И.Уткин. стр.166
- <sup>8</sup> Jan Aart Scholte. 2000. *Globalization: a critical introduction*. Wales: Palgrave.